



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/48

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а" заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэрлэх, тууврын замд саатуулах, хорио цээрийн хяналтанд авах журам"-ын 2,6-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 2, 4 дүгээр багуудын нутаг дэвсгэрт отор нүүдлээр шилжиж ирсэн малын шилжилт, хөдөлгөөнд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Аюушжав-Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч
Гишүүд: Р.Даваасүрэн-Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч

Д.Даваацэрэн-2 дугаар багийн Засаг дарга

Г.Пүрэвтогтох-4 дүгээр багийн Засаг дарга

Л.Батчулуун-"Хустын рашаан" Мал эмнэлэг

М.Янжинлхам-"Санги хайрхан" Мал эмнэлэг

Г.Дондогсэрчин-Иргэний төлөөлөл

2. Отор нүүдлээр ирсэн малчдын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, отор нүүдэл хийх явцад болон гэрээгээр тогтоосон нутаг дэвсгэрт зүй бусаар хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх, хашаа, хороог халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллан, бичмэл тайланг баримтжуулан заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлэхийг (П.Аюушжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010095